ЭРШҮҮД БАЙДАЛ БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

АЖЛЫН ДЭВТЭР

УЛААНБААТАР
2021

In partnership with Canada

IDLO
Creating a Culture of Justice
International Development Law Organization

ЭРШҮҮД БАЙДАЛ БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

АЖЛЫН ДЭВТЭР

ЭХНИЙ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР
2021

Тус ажлын дэвтрийг Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ)-ын хэрэгжүүлж буй "Монгол Улсад жэндэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх нь" (2019-2022) төслийн хүрээнд боловсруулан, хэвлэв.

Төслийн зорилго нь иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлсэнээр жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжийг нэмэгдүүлж, хохирогч-төвтэй үйлчилгээг хүргэж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх юм.

Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.idlo.int цахим хуудас болон төслийн @IDLOmongol Фэйсбүүк хуудаснаас авна уу.

Ажлын дэвтэр нь олон нийтийн дунд ялангуяа хөвгүүд, эрэгтэйчүүдэд жендэрт суурилсан хүчирхийлэл (ЖСХ)-ийн суурь шалтгаан нь эцгийн эрхт ёсноос улбаатай, нийгэмд тогтсон хэвшмэл ойлголттой салшгүй холбоотой бөгөөд хор уршиг, үр дагавар нь хувь хүн, гэр бүл, нийгэмд үлддэг талаар хэлэлцүүлгээр дамжуулан ойлголт өгнө. Үр дүнд нь ЖСХ-ийг үл тэвчих хандлагыг хэвшүүлж, ЖСХ-тэй тэмцэхэд хөвгүүд, насанд хүрсэн эрэгтэйчүүдийн оролцоог хангаж, хамтран шийдэл гаргах, эршүүд байдал хувьсан өөрчлөгдөж байгааг эргэцүүлж, ухамсарлан хүлээж авах, эерэг өөрчлөлт өөд тэмүүлэхэд нь туслах болно.

Ажлын дэвтэр нь иргэний нийгмийн байгууллагуудад зориулан гаргасан чиглүүлэгчийн гарын авлагын нэг хэсэг болно.

Боловсруулсан: Г. Түмэннаст, МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхимийн дэд профессор

Хянасан: С. Одончимэг, Төслийн зохицуулагч

Хэвлэлийн дизайн: Б.Мишээл

Зохиогчийн эрх © 2021. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)

Энэ ажлын дэвтрийн агуулга, илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага болон төслийн санхүүжүүлэгч байгууллагын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно.

АГУУЛГА

1. Эршүүд байдал ба эцгийн эрхт ёсны тухай

1.1 Эршүүд байдлын тухай уламжлалт болон орчин үеийн урлаг дахь өгүүлэмж 5

1.2 Жендэрийн тэгш бус байдал ба эрчүүдийн ноёрхол 10

1.3 Эцгийн эрхт ёс гүн гүнзгий үндэстэй байдаг 13

2. Жендэрийн нийгэмшил: Эршүүд болон эмэгтэйлэг болж төлөвших нь

2.1 Жендэрийн хэвшмэл ойлголтын тухай 20

2.2 Жендэрийн нийгэмшил хэрхэн явагддаг вэ? Хөвгүүд эрчүүд болох нь 24

2.3 Эрчүүдийн нийгэмшлийн өөрчлөгдөн буй нөхцөл байдал 28

3. Эршүүд байдал ба жендэрт суурилсан хүчирхийлэл

3.1 Жендэрт суурилсан хүчирхийллийн тухай 30

3.2 Охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл эцгийн эрхт ёсонд суурилах нь 35

3.3 Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ 37

4. Эцгийн эрхт ёсноос хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдал өөд

4.1 Эрчүүд яагаад өөрчлөгдөх хэрэгтэй вэ? 39

4.2 Өөрчлөлтийн төлөө эрчүүд юу хийж чадах вэ? 44

4.3 Хувьсан өөрчлөгдөгч эрчүүдийн ертөнцийн туршлага 45

1

ЭРШҮҮД БАЙДАЛ БА ЭЦГИЙН ЭРХТ ЁСНЫ ТУХАЙ

1.1 ЭРШҮҮД БАЙДЛЫН ТУХАЙ УЛАМЖЛАЛТ БОЛОН ОРЧИН ҮЕИЙН УРЛАГ ДАХЬ ӨГҮҮЛЭМЖ

Монгол ардын болон нийтийн дуунд ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ хүнийг ШИНЖ ЧАНАРААР нь хэрхэн тодорхойлсон байдгийг бодож тус бүр 5 жишээ бичнэ үү.

1. "Учиртай гурван толгой" дуулалт жүжгийн гол дүр Нансалмаа болон Юндэн хоёр

2. МУГЖ дуучин С. Жавхлан, Т. Баясгалан нар

	ЭРЭГТЭЙ шинж	ЭМЭГТЭЙ шинж
1		
2		
3		
4		
5		

Хүний төрөлхөөс өгөгдсөн хромосомын бүтэц, даавар болон физиологийн харьцангуй ялгаануудыг илэрхийлж буй зүйл бол **хүйс** юм. Харин, нийгэм соёлын орчноор тодорхойлогдож буй зүйл **жендэр** юм.

Хүйс болон жендэр ямар ялгаатай вэ?



ЭРЭГТЭЙЧҮҮД БА ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТАЛААРХ НИЙГЭМ, СОЁЛЫН ЯВЦУУ БОЛОН ХЭВШСЭН ОЙЛГОЛТ

“ЭРШҮҮД БАЙДАЛ”-ЫН ЖИШЭЭ	“ЭМЭГТЭЙЛЭГ БАЙДАЛ”-ЫН ЖИШЭЭ
Манлайлан дагуулагч	Манлайллыг дагалдагч
Гэр бүлийн санхүүгийн асуудлыг шийднэ	Гэр бүлдээ санаа тавьж, анхаарна
“Төрөлхийн” нийгмийн өндөр түвшний, илүү орлоготой ажилд сайн (жишээ нь байгууллагын дарга)	“Төрөлхийн” нийгмийн доод түвшний, цалин багатай ажилд сайн (жишээ нь байгууллагын захиргааны албан тушаал)
Зарим ажилд “төрөлхийн” сайн (жишээ нь жолоо барих)	Зарим ажилд “төрөлхийн” сайн (жишээ нь хоол хийх)
Чанга байх	Мэдрэмжтэй байх
Хүссэндээ хүрэх	Хүссэнийг нь өгөх
Эмзэг үед сэтгэл хөдлөлөө нуух (гуниг, айдас, түгшүүр)	Эмзэг үед сэтгэл хөдлөл гаргах (гуниг, айдас, түгшүүр)
Чадалтай байх	Удам залгуулах
Эрчүүдийг сексийн хувьд сонирхохгүй байх	Эмэгтэйчүүдийг сексийн хувьд сонирхохгүй байх
Хүчирхийллийн хохирогч бус хүчирхийлэгч	Хүчирхийлэгч бус хүчирхийллийн хохирогч

Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн ялгааны талаарх нийгэм соёлын нийтлэг ойлголтыг эвдсэн Америкийн антропологич Маргарет Мидийн 1930-аад онд Шинэ Гвинэйн гурван овог аймагт хийсэн судалгааны үр дүн:

АРАПЕШ (ARAPESH) ОМОГТ

эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд нэгэн адил гэр бүлдээ найрсаг, үр хүүхэддээ хариуцлага хүлээж, хамтран ажилладаг байв. Энэ нь ардчилал удаан оршин тогтносон, тэгш эрх илүү хангагдсан барууны нийгмүүдтэй төстэй байжээ. Омгийн зан үйлийг удирдах хүнийг дундаасаа сонгодог бөгөөд хүч эрх мэдлийн төлөөх тэмцэл намжмал, тайван байна.

МУНДУГУМОР (MUNDUGUMOR) ОМОГТ

эрчүүд ч, эмэгтэйчүүд ч нэгэн адил түрэмгий, бие биедээ дайсагнасан бөгөөд хүч, эрх мэдлийн төлөө эцэг эх, үр хүүхдүүд ч хоорондоо тэмцэлдэнэ.

ЧАМБУЛД (CHAMBULL) ОМОГТ

Эрчүүд болон эмэгтэйчүүдийн зан байдал өөр хоорондоо адилгүй төдийгүй, хэвшмэл ойлголтыг бүрнээ эвджээ. Тэнд эмэгтэйчүүд ноёрхсон, удирдан зохион байгуулах төдийгүй, омгийн эдийн засгийн чухал ажлуудыг, тухайлбал, засаг барьж, даавуу нэхэж, худалдаа хийдэг байхад, эрчүүд нь биеэ гоёж, сонирхогчдын урлагаар хичээллэж, баяр цэнгэл зохиохыг боддог байна. Энд орон суурцыг эмэгтэйчүүдийн орон гэр гэж үзэх ба эмэгтэйчүүд эрчүүдтэй эрх тэгш харьцаж, учраа олохын оронд бяцхан хөвгүүд мэт хандана.

Тус судалгаагаар товчхондоо эрэгтэй эмэгтэй хүмүүсийн “байгалиас өгөгдсөн” үүргийн тухай хэвшсэн ойлголтыг өөрчилж байгаа төдийгүй, эрчүүд хийгээд эмэгтэйчүүдийн жендэрийн үүрэг нь төрөлх хүйсээс илүүтэй соёл, нийгмийн байдлаар тодорхойлогддог, төлөвшдөг болохыг харуулж байна.

Тэгвэл та өнөө үед нийгмээс оноосон жендэрийн үүргийг эвдсэн жишээг бодож бичнэ үү.

Дүгнэн үзвэл эрчүүд, эмэгтэйчүүдэд байх эршүүд, эмэгтэйлэг шинж чанарууд буюу тэдгээрээс бидний хүлээдэг жендэрийн үүрэг нь байгалиас өгөгдсөн гэхээсээ нийгмийн явцад бүрэлддэг ажээ.

1.2 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ БА ЭРЧҮҮДИЙН НОЁРХОЛ

Жендэрийн тэгш бус байдал гэдэг нь нийгмийн зүгээс хүмүүсийг ямар хүйстэйгээс хамааран тэдгээрт ижил тэгш бус хандах үзэгдэл бөгөөд энэхүү хандлагаас үүдэн нийгмийн амьдралд ижил бус байр суурь, боломж бүрэлдэхийг хэлнэ.

Монголын нийгэмд дараах салбарын алинд нь жендэрийн тэгш бус байдал ямар хэлбэрээр хамгийн их байдаг вэ?

ГЭР БҮЛД	БОЛОВСРОЛ	АЖИЛ ХӨДӨЛМӨР	УЛС ТӨР

ЭРЧҮҮДИЙН НОЁРХОЛ ХИЙГЭЭД ТҮҮНИЙ ОРЧИН ҮЕИЙН НИЙГЭМД АМЬ БӨХТЭЙ ОРШСООР БАЙГААГ ХАРУУЛСАН СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

- Францын социологич Бүрдю (Pierre Bourdieu, 1998) "Эрчүүдийн ноёрхол" хэмээх бүтээл туурвисан бөгөөд орчин үеийн нийгэмд эрэгтэйчүүд жендэрийн хувьд ноёрхож байдаг нь нийгмийн бүтэц, тогтолцооны хувьд бат бөх байгааг илрүүлсэн байна. Бүрдю өнөөгийн нийгэмд жендэрийн үүрэг, бүр нарийвчилбал эрчүүдийн ноёрхол өдөр тутмын амьдралд хэрхэн хэрэгжиж байгааг тайлбарласан.
- Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаанд бие махбодын хүчирхийлэл, дарамт шахалт, албадлага, болон айлган сүрдүүлэх явдал урьд өмнөхөөс хамаагүй багасаж буй ч бэлгэдлийн хүчийг (хүчирхийллийг) тайлбарлахгүйгээр эрчүүдийн ноёрхлыг, цаашилбал өдөр тутмын амьдрал дахь эрчүүдийн үйлдэж буй бие махбодын хүчирхийллийг тайлбарлахад хэцүү байх болно. Эрчүүдийн ноёрхлын шалтгаан болж буй бэлгэдлийн хүч (хүчирхийлэл) нь хүмүүсийн амьдралд ноёрхож буй зуршилд суурилсан ертөнцийг үзэх үзэл, нийгмийн дэг ёсны тусгал болж байна. Ардчилал, хүний эрх өсөн тэлэх тусам жендэрийн эрх тэгш байдал хангагдаж, охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг тогтолцоо өсөн томорч байна.

Гэвч, Бүрдюгийн бүтээлд буй нэг гол санаа нь эрчүүдийн ноёрхол нь өнөөг хүртэл нийгмийн институц, байгууллага, бүлгүүдэд амь бөхтэй хадгалагдан оршсоор буйг дүгнэжээ. Түүнийхээр эрчүүдийн ноёрхол нь зөөлөн, далд, ухамсаргүй байдлаар нийгмийн бүтцэд оршсоор байна.

Жендэрийн тэгш бус байдал нь Эрчүүдийн ноёрхолтой холбоотой гэх дээрх сэтгэгчийн үзлийг та хэрхэн хүлээн авч байна вэ?



Дүгнэн үзвэл орчин үеийн нийгэм дэх жендэрийн тэгш бус байдал нь эрчүүдийн ноёрхлоор нөхцөлддөг бөгөөд чимээгүй, далд, зөөлөн аядуу хэлбэрээр өөрийгөө хадгалсаар байна.

Жендэрийн тэгш бус байдлын хувьд боловсрол, гэр бүл, ажил хөдөлмөрийн салбарт эмэгтэйчүүд зарим талаар давамгайлж байгаа мэт сэтгэгдэл төрөх боловч, агуулга, чанарын хувьд эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр байна. Энэ нь дээрх ноёрхол оршсоор буйн илрэл болж байна.

1.3 ЭЦГИЙН ЭРХТ ЁС ГҮН ГҮНЗГИЙ ҮНДЭСТЭЙ БАЙДАГ

Эцгийн эрхт ёс гэж юу вэ?

Өнөөгийн Монголын гэр бүлийн амьдралд хэрхэн илэрч байна вэ?

ДЭЛХИЙН УЛС ОРНУУД ДАХЬ ЭХИЙН ЭРХТ ЁС ХАДГАЛАГДАЖ ИРСЭН УГСААТАН, ОВОГ АЙМГУУД



Тайлбар: Зургийн зүүн дээд булангаас Хятад улс Мусуо үндэстэн, дунд нь Индонези улс Минангкабау угсаатан, баруун дээд буланд Энэтхэгийн Каши аймаг, баруун доод булан Кени улс дахь Уможи аймаг, доод талын дунд Гана улс дахь Акан, зүүн доод булан Коста Рика улсын Брибри аймаг.

Дэлхийн хаа нэгтээ соёлуудад эхийн эрхт ёс нь эцгийн эрхт ёстой зэрэгцэн оршсоор байгаа нь эцгийн эрхт ёс жендэрийн дэг ёс, гэр бүлийн харилцааны цорын ганц заяагдмал зохион байгуулалт гэж үзэж болохгүйг харуулж байна.

Эцгийн эрхт ёсны уламжлалын талаар Танд ямар бодол төрж байна вэ?

Эцгийн эрхт ёс өөрчлөгдөж байна уу? Хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар тэмдэглэл хийгээд бүлгийн хэлэлцүүлэгт саналаа өгнө үү.

	Эцгийн эрхт ёсны эршүүд байдал	Хувьсан өөрчлөгдөгч буй эршүүд байдал
Гэрт	Эр нөхөр эхнэрээрээ хоол хийх, цэвэрлэх, хүүхэд асрах бүх ажлыг хийлгэдэг. Тэрээр гэр бүлийнхээ гол шийдвэрийг ганцаараа гаргана.	Эрчүүд гэрийн ажил, хүүхэд асрах үүргийг эхнэртэйгээ хуваалцана. Эр нөхөр нь гэр бүлийн чухал шийдвэрийг эхнэртэйгээ зөвлөлдөж хамт гаргана. Бусад хүнийг жендэрээс нь үл хамааран үнэлж, хүндэтгэхэд эхнэртэйгээ хамтран хүүхдүүдээ сургана.
Ажил дээр	Эрчүүд хуралд идэвхтэй оролцож их ярьдаг, гэхдээ хурал тараад цэвэрлэгээг эмэгтэйчүүдэд орхиод явдаг учир нь үүнийг эмэгтэйчүүдийн ажил гэж тэд үздэг. Жишээ нь: ажилтнуудын төрсөн өдрийг тэмдэглэх, оффисыг цэвэр, аятайхан байлгах.	Ажлын байранд жендэрийн тэгш байдлыг дээшлүүлэх чиглэлээр эрэгтэйчүүд зан үйлээ өөрчлөхийн тулд харилцан дэмжлэг үзүүлнэ. (ж.нь: эмэгтэйчүүдэд ихэвчлэн оноогддог ажлыг хамтарч хийх, ажилчдын хуралд ижил тэгш оролцоог хангах, гэх мэт).
Гудамжинд	Эрчүүд эмэгтэйчүүдийн биеийг ичгүүргүйгээр ширтэж, эмэгтэйчүүдэд бэлгийн дарамт үзүүлнэ (үг хэл, үйл хөдлөлөөр). Эрэгтэйчүүд өөр эр хэн нэгэн бүсгүйд бэлгийн халдлага үйлдэж байгааг хараад үл тоож, туслахгүй орхино.	Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандаж, үл хүндэтгэсэн эрчүүдийг хориглох. Бэлгийн хүчирхийллийн гэрч болсон тохиолдолд зогсоох, хохирогч эмэгтэйд туслахаар чадах бүхнээ хийнэ.

Эх сурвалж: Эр хүйс ба охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай ойлголт, UN WOMEN, Сургалтын төв, 2016

Эцгийн эрхт ёс
өөрчлөгдөж байна.
Охид, хөвгүүдийг
ялгаж хандах нь улам
бүр багаслаа.
Хүүхдээ хамтаар өсгөж
хүмүүжүүлэх болжээ.

Исламын шашинтай улс орнууд, кастын тогтолцоо бүхий Энэтхэг, өмнөд америкийн болон африкийн зарим орнуудыг эс тооцвол, эцгийн эрхт ёсны уламжлал улам бүр өөрчлөгдөж байна.

ЭЦГИЙН ЭРХТ ЁСНЫ ЭРЧҮҮДИЙН ЕРТӨНЦӨӨС ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ ЭРЧҮҮДИЙН ЕРТӨНЦ РҮҮ ШИЛЖИЖ БАЙНА

? Эцгийн эрхт ёсны эрчүүдийн ертөнц хувьсан өөрчлөгдөж байна уу? Та үүнтэй санал нэгдэж байна уу?



Дүгнэн үзвэл энэ бүлгийн эхэнд авч үзсэнчлэн бидний мэдэх эршүүд байдал, эр хүний гэгдэх чанарууд, тухайлбал хатуу хүтүү ажил хийдэг, эр зоригтой, зэр зэвсэг агсдаг, багаж хэрэгсэл эзэмшдэг зэрэг нь бурхны хуваарилалт, байгалиас заяагдсан мөн чанар биш болох нь Мидийн угсаатны судалгааны жишээн дээр харагдсан билээ. Эршүүд байдлын нэгэн адил эцгийн эрхт ёс ч тийм байгалиас буюу угаас заяагдсан зүйл биш ажээ.

2 ЖЕНДЭРИЙН НИЙГЭМШИЛ: ЭРШҮҮД БОЛОН ЭМЭГТЭЙЛЭГ БОЛЖ ТӨЛӨВШИХ НЬ



2.1 ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТЫН ТУХАЙ

Та бүхний хүүхэд насанд гэр бүл, сургууль бусад хүрээнд хөвгүүд ийм, тийм байх ёстой гэсэн ямар шаардлагууд байсан вэ? Түүнээс тодорхой зүйлсийг эргэн дурсаж хуваалцана уу?

Дээрх нөхцөл байдал одоо өөрчлөгдсөн үү? Тийм бол хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

"Хань" МУСК, 1975 он.
Найруулагч: Бадрахын Сумхуу

Энэхүү кинонд удам дамжсан бөх эцэг хүү хоёрын дүрээр уламжлалт болон орчин үеийн гэр бүлийн эрчүүдийн жендэрийн хүлээлт, үүрэг ролийн зөрчлийг тод тусган харуулжээ.

АМЬДРАЛЫН МӨЧЛӨГҮҮД ДЭХ ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ОЙЛГОЛТУУДЫН ЗАРИМ ЖИШЭЭ:

Балчир насанд:

- Охид хүүхэлдэйгээр, хөвгүүд ачааны машинаар тоглох ёстой.
- Хөвгүүдийг хөх, ногоон өнгөнд дуртай болгох ёстой; охидод улаан, ягаан өнгөтэй зүйл болно.
- Хөвгүүд даашинз эсвэл охидын ямар нэг хувцас, эдлэл хэрэгслийг өмсөх, хэрэглэх ёсгүй.

Өсвөр насанд:

- Охидууд уншихдаа, хөвгүүд математикт илүү сайн байдаг.
- Охид биеэ зөв авч явах ёстой, хөвгүүд хайнгадуу байх ба заримдаа хэм хэмжээг зөрчих хүлээлт бий болдог.
- Охид, хөвгүүд шиг STEM (ШУ-ны) хичээлийг сонирхдоггүй.
- Хөвгүүд спортоор хичээллэж, илүү бүтээлч эрэл хайгуул хийхээс татгалзах ёстой.
- Хөвгүүд бие биендээ андгай тавин, үнэнчээ харуулахын тулд зарим гаж хэрэглээг (архи, тамхи гэх мэт) харуулах хэрэгтэй.
- Бүлэглэл бол хөвгүүдийн охидоос ялгарах шинж чанар бөгөөд бүлэглэлийн гадна үлдэх нь шоовдор, ичгүүртэй зүйл.
- Хөвгүүд, эрэгтэйчүүд эр хүн гэдгээ батлахын тулд хүчирхийлэл, түрэмгийлэл хийхийг шаарддаг.
- Хүчирхийлэл, түрэмгийлэл хийдэггүй хүү бол дээрэлхүүлэх нь ойлгомжтой.
- Охидууд туранхай, үзэсгэлэнтэй байх ёстой бөгөөд ингэснээр эрчүүдэд таалагдах болно.

Насанд хүрэгчид:

- Эмэгтэйчүүд ойр дотны хамтрагчийнхаа хүчирхийлэлд өртсөн ч харилцаагаа хадгалж үлддэг тул сул дорой байдаг.
- Хүүхэд хүсдэггүй эмэгтэйд ямар нэгэн буруу зүйл байдаг.
- Нүүрэмгий, шаргуу эмэгтэйчүүд бол эмэгтэйлэг бус бөгөөд дажгүй эмэгтэй биш.
- Эмэгтэйчүүд бол байгалийн асран хамгаалагч юм, харин эрчүүд бол байгалийн удирдагчид.
- Нөхрийн дэмжлэг бий тул эмэгтэйчүүдэд ижил цалин шаардагдахгүй.
- Хүүхэдтэй эмэгтэйчүүд ажилдаа өөрийгөө бүрэн зориулдаггүй.
- Гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөдөг эрчүүдийн хувьд эршүүд чанар багатай, эсвэл гэр бүлийнхээ санхүүг шийдэх чадваргүй.
- Хосуудын хувьд хүүхэд эсвэл ахмад настнуудаа асрахын тулд эмэгтэйчүүд нь чөлөө авах ёстой.
- Эмэгтэйчүүд хэт их сэтгэл хөдлөлтэй байдаг, ялангуяа жирэмсэн байхдаа зарим төрлийн ажил хийх боломжгүй байдаг.
- Эрчүүд хэт эмэгтэйлэг бус бөгөөд "эмэгтэйчүүдийн илүү сайн хийдэг" зүйлийг хийх нь сэтгэл хөдөлгөх зүйл биш.
- Эмэгтэйлэг чанар багатай эсвэл эрчүүдийн давуу талыг үгүйсгэдэг эмэгтэйчүүд бол лесби хүмүүс.
- Түрэмгий, дайчин биш эрчүүд эр хүний шинжгүй бөгөөд ижил хүйстэн байж магадгүй.
- Ижил хүйстэн хосууд сайн эцэг эх болж чадахгүй.
- Трансжендэр эсвэл хүйсээ тодорхойлдоггүй хүн туйлын буруу юм.

Дээрх хэвшмэл ойлголтуудыг халахад таны оролцоо ямар байх вэ?

Дүгнэн үзвэл нийгэм байнга хувьсан өөрчлөгдөж ирсэн бөгөөд өнөөдөр ч бидний уламжлалт гэгдэх ертөнц өөрчлөгдсөөр байна. Түүний хүрээнд орчин үеийн хөвгүүд тэдний өвөө, аавын үеийнх шигээ уламжлалт жендэрийн үүрэгтэй эрчүүд биш болж байна. Тэд эцгийн эрхт ёсны дэг ёсыг аажмаар гээсэн амьдралын орчинд өсөж байна.

2.2 ЖЕНДЭРИЙН НИЙГЭМШИЛ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ? ХӨВГҮҮД ЭРЧҮҮД БОЛОХ НЬ

Өнөөдөр хөвгүүд эрчүүд болон нийгэмшихэд дараах бүлэг, байгууллага зэрэг нийгэмшлийн хүрээлэл хэрхэн нөлөөлж байгаа вэ? Тэмдэглэнэ үү.

Гэрт:

Сургуульд:

Олон нийтийн мэдээлэл, сошиал ертөнцөд:

Хөвгүүд эрчүүд болоход бусад эрчүүдийн ертөнц хэрхэн нөлөөлдөг вэ?

ГЭР БҮЛ

- Аав, өвөө
- Ах нар
- Авга, нагац ах

СУРГУУЛЬ

- Ангийн болон бусад (эрэгтэй) багш
- Сургуулийн удирдлага ба бусад эрэгтэйчүүд
- Үе тэнгийн хөвгүүд

ОЛОН НИЙТ

- Нэг байр, гудам, айл саахалт, гол усны эрчүүд
- Аав, ээжийн найзууд
- Хороо, багийн дарга, соёлын төвийн эрхлэгч
- Танихгүй ах нар

ОЛОН НИЙТ (СОШИАЛ) МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

- Урлагийн одод
- Улс төрчид
- Инфлүенсэрүүд

Жендэрийн нийгэмшилд идеаль буюу тухайн хүйсийн буюу хүйсийн баримжаа, илэрхийлэл (identity) чухал бөгөөд үүнд өөрийн хамаатуулж буй жендэрийн хүрээнд даган дуурайгчдыг бий болгож байдаг. Жендэрийн нийгэмшлийн жишиг болсон хүмүүс нь гэр бүл, ойр хүрээллийн хүмүүс байхаас гадна олны танил хүмүүс байдаг.

ХҮЙС НИЙГМИЙН ХУВЬД БҮТЭЭГДДЭГ ТУХАЙ СУДЛААЧИЙН ДҮГНЭЛТ

Францын философич, феминист Симон де Бувуа (Simone de Beauvoir)

Пиноккио хүүхэлдэйг урлан буй нь

Түүний 1949 онд бичсэн "Хоёр дахь хүйс" бүтээлдээ:
"Эмэгтэй хүн болж төрдөггүй, харин бүтээгддэг"

Симон де Бувуагийн дүгнэлттэй адилтгавал,
Эр хүн болж төрдөггүй, харин бүтээгддэг.

Товчхондоо жендэрийн нийгэмшилд тэгш эрх, шударга ёсны үзэл санаа аажмаар нөлөөлсөөр байна.

Дүгнэн үзвэл хүн амьдралынхаа явцад бусад хүмүүсийн нөлөөн доор өөрт заяасан биологийн хүйсэнд суурилсан нийгэм, соёлын шинж чанарыг эзэмшиж байдаг.

Хөвгүүд балчир, хүүхэд нас, өсвөр үе, цаашилбал насанд хүрсэн эрчүүд, өвгөчүүд ч эр хүн гэж нийгмээс хүлээж буй шинж чанарт нийцэх гэж хичээсээр амьдралыг туулдаг. Тиймээс тэд эр хүйстэй болж төрдөг ч, харин эр хүн болж бүтээгддэг байна.



2.3 ЭРЧҮҮДИЙН НИЙГЭМШЛИЙН ӨӨРЧЛӨГДӨН БУЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эрэгтэйчүүд эцгийн эрхт ёсны үед жендэрийн хэвшмэл ойлголт, жендэрийн үүргийн хүрээнд нийгэмшдэг байсан бол хувьсан өөрчлөгдөгч жендэрийн хүрээнд нийгэмшиж байна.

Өдгөө хүүхдүүдийн жендэрийн нийгэмшлийн үйл явц өөрчлөгдөж байна.

Жендэрийн нийгэмшлийн орчин өөрчлөгдөж байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү? Тийм, эсвэл үгүй бол яагаад?

Дүгнэн үзвэл бидний амьдарч буй нийгэм, түүний харилцаа, орчин өөрчлөгдсөөр байна. Эр хүн болж бүтээгдэх үйл явц, эр хүн ийм байх ёстой гэсэн хэвшмэл ойлголт өөрчлөгдөж байгаа учраас эр хүн байхын тулд гүйцэтгэх ёстой жендэрийн үүрэг ч өөрчлөгдөж байна.

3 ЭРШҮҮД БАЙДАЛ БА ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ



3.1 ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Монгол Улсын хуулийн 4.1.8 зүйлд **Жендэрт суурилсан хүчирхийлэл** гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй гэж тодорхойлжээ.

Жендэрт суурилсан хүчирхийлэл эдгээр орон зай, талбаруудад хэрхэн ямар хэлбэрээр илэрдэг вэ?

Гэр оронд: _____

_____

Ажлын байранд: _____

_____

Үйлчилгээний байгууллагад (боловсрол, эрүүл мэнд, халамж, хорих гм): _____

_____

Олон нийтийн газар (гудамж, талбай, нийтийн тээвэр, үзвэр үйлчилгээ): _____

_____

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААР ОЛОН УЛСАД ТОДОРХОЙЛОХДОО:

Жендэрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундах нийгмээр тодорхойлогдсон (өөрөөр хэлбэл жендэрийн) ялгаанд суурилсан хийгээд хүмүүсийн хүсэл зорилгын эсрэг аль нэг хор хөнөөл бүхий үйлдлүүдийг багтаасан нийтлэг ойлголт юм.

Салбар хоорондын байнгын зөвлөлөөс (IASC) гаргасан ЖСХ-тэй тэмцэх нэгдмэл үйл ажиллагааны удирдамж

Жендэрт суурилсан хүчирхийлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын нийгмээс тогтоосон (буюу жендэрийн) ялгаанд үндэслэн хүний хүсэл зоригийн эсрэг үйлдсэн хор хөнөөлтэй аливаа үйлдэл юм.

НҮБ-ын төрөлжсөн байгууллага хоорондын байнгын хороо

Жендэрт суурилсан хүчирхийлэлд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэл, ураг төрлийн хүчин, ажлын байрны бэлгийн дарамт, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэг зэрэг бүхий л төрлийн хүчирхийллийн жендэртэй холбоотой бүрэлдэхүүн хэсгүүд багтдаг.

НҮБХАС, ҮСХ-ны 2017 онд хийсэн ЖСХ-ийн нөхцөл байдлын талаарх "Нүцгэн үнэн" судалгаанд Монгол Улсад эмэгтэйчүүдийн 3 хүний 1 нь бие махбодын эсхүл бэлгийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн тухай дурджээ.

? Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид нь дийлэнхдээ охид, эмэгтэйчүүд байдаг тухай дуулаад танд ямар сэтгэгдэл төрж байна вэ?

1. ЖСХ хэмээх ойлголт нь аливаа нийгэмд эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн хоорондтэгш бус байдал хэрхэн системтэй үйлчилж буйг харуулж буй охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хамгийн суурь бөгөөд нэгдмэл шинж бүхий хүчирхийллийн үйлдлүүдийг илэрхийлж байна.

2. ЖСХ нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй нягт хамааралтай ч, ЖСХ-ийн хохирогчид нь дан эмэгтэйчүүд байдаг гэсэн үг биш юм. ЖСХ-ийн хохирогчдын дийлэнх нь охид, эмэгтэйчүүд байдаг ч, эрэгтэйчүүд эрэгтэй хүний тухай нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтод нийцээгүйнхээ төлөө доромжлуулах, зодуулах зэргээр өртөж болдог.

3. Гэвч охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон бусад жендэрт суурилсан хүчирхийллийн эзлэх хувь хэмжээ онцгой өндөр хэвээр байна. Дэлхий дахинд хамгийн түгээмэл хэдий ч хамгийн бага мэдээлэгддэг хүний эрхийн ноцтой зөрчилд тооцогддог.

Дүгнэн үзвэл эцгийн эрхт ёс хадгалагдсаар байгаа учраас эрчүүдийн ноёрхол оршсоор байна. Эрчүүдийн ноёрхол нь эрчүүд давамгайлсан жендэрийн тэгш бус байдлыг бүтээсээр байгаа тул ийм нийгэмд жендэрт суурилсан хүчирхийллийн дийлэнхийг эрчүүд үйлдэж байна.

3.2 ОХИД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ ЭЦГИЙН ЭРХТ ЁСОНД СУУРИЛАХ НЬ

Жендэрт суурилсан хүчирхийлэл болон эцгийн эрхт ёс хоёрын холбоо, харилцааг хэрхэн төсөөлж байна вэ?

Та бүхэн эцгийн эрхт ёсны эрчүүдийн давамгай байдлын үе дэх зарим ойлголтуудын талаар уншаад өөрсдийн эргэцүүллийг тус бүрд нь бичнэ үү.

Эрчүүдийн давуу талын тухай эцгийн эрхт ёсны итгэл үнэмшил:

"Жинхэнэ эр хүний" үйл хөдлөл хүртэл бүхэлдээ хүчирхэг, түрэмгий байдлыг илэрхийлж байдаг. Энэ нь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн гол үндэс мөн.

Эрчүүдийн нийгмийн харилцаан дахь хүчирхийлэл:

Бага насандаа гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байсан хөвгүүд насанд хүрээд хүчирхийлэгч болох хандлагатайг тодорхойлсон байна.

Эршүүд байдал ба хүчирхийлэл:

Эр хүн "жинхэнэ эр хүн" болохоо батлан, хамгаалахын тулд хүчирхийлэл үйлдэх нь нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг арга хэлбэр хэвээр байна.

Эрчүүдийн давамгайлал, гетеросекс (эсрэг хүйс), хүчирхийлэл:

Олон нийгэмд эр хүйсийн давуу тал, гетеросекс гэсэн ойлголтууд хоорондоо хүчирхийлэл, түрэмгийллээр холбогддог. Асар ялгаатай соёлуудын хоорондч эр хүн хянах аргагүй бэлгийн хүсэлтэй, харин эмэгтэйчүүд төрөлхийн сексийн хувьд идэвхгүй байх ёстой гэсэн итгэл үнэмшил нийтлэг оршсоор байна.

Эрчүүдийн давамгайлал ба милитаризм:

Эрчүүдийг зэвсэглэсэн мөргөлдөөнд татан оруулах оролдлогод эр хүйсийн давуу талыг илэрхийлсэн мессеж, дүрслэлийг ихэвчлэн ашигладаг. Эр хүйсийн давуу тал, хүчирхийлэл нь милитаризм буюу зэр зэвсэг дайнаар хөөцөлдөх үзлээр холбогдоно.

3.3 ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Таны бодлоор эцгийн эрхт ёсны эр хүйсийн давамгайллын эсрэг эрэгтэйчүүд юу хийж чадах вэ?

Баг багаараа хэлэлцэж санал бодлоо нэгтгэн бичнэ үү.

Хувь хүний хувьд	
Эцэг эхийн хувьд	
Бусад эрчүүдийн найзын хувьд	
Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйн найзын хувьд	
Нийгмийн гишүүний хувьд	
Хууль сахиулах байгууллагын хувьд	
Нийгмийн манлайлагчийн хувьд	

Дүгнэн үзвэл жендэрийн тэгш бус байдал, жендэрт суурилсан хүчирхийллийн үндэс болсон эцгийн эрхт ёсыг өөрчлөх, түүнээс хувьсан өөрчлөгдөгч эрчүүдийн ертөнц өөд шилжихэд эрчүүдийн оролцоо амин чухал юм. Тиймээс, эрчүүд энэ нийгэмд найз нөхөд, хань ижил, хүү, хөрш, хамтран ажиллагч, хөндлөнгийн гэрч гэх мэт аль ч дүрээ хэрэгжүүлэхдээ дээрх өөрчлөлтийг эрхэмлэн, түүнд гар бие оролцох ёстой ажээ.

4 ЭЦГИЙН ЭРХТ ЁСНООС ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨГЧ ЭРШҮҮД БАЙДАЛ ӨӨД



4.1 ЭРЧҮҮД ЯАГААД ӨӨРЧЛӨГДӨХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

"Эрчүүд өөрчлөгдөх нь зөвхөн эмэгтэйчүүдийн төлөө зүйл үү? Үүний үр нөлөө, ач тусыг зөвхөн охид, эмэгтэйчүүд хүртэх үү?"

Энэ асуултыг эргэцүүлээд өөрийн хариултыг тэмдэглэнэ үү.

Та дараах бодомжуудтай санал нийлж байна уу? Бодомжуудыг уншин хариулт өгөөд өгсөн хариултаа эргэцүүлж тайлбарлана уу.

Харилцааны ашиг сонирхол	Тийм	Үгүй	Хэлж мэдэхгүй байна	Тайлбар
Эрчүүд гэр бүл, хамт олон, эхнэр, хамтрагч, ээж, эгч, нагац, найз, охин, зээ, найзууд, ангийнхан, ажлынхан, хөрш эмэгтэйчүүдтэй зэрэгцэн амьдардаг. Тэдэнтэй харилцах сэтгэл ханамж, аз жаргал нь эрэгтэй хүн бүрийн амьдралын чанарыг тодорхойлох томоохон хэсэг болно.				
Тэдний хайрлан, харилцдаг охид, эмэгтэйчүүдийн амьдралд хохирол учруулдаг жендэрийн тэгш бус байдлын тогтолцоо эргээд эрчүүдийн өөрсдийнх нь амьдралд ч хохирол учруулдагийг эрэгтэйчүүд мэдэрдэг.				
Олон эрчүүд өөрсдийн хүүхдүүдийн төлөө золиос гаргаж, залуу охидод айдас хүчирхийлэлд өртөхгүй ертөнцөд амьдрах боломжийг өгөхийг хүсдэг. Энэ нь жендэрийн тэгш байдлыг эрэгтэйчүүд дэмжих ёстой хүчирхэг шалтгаан юм.				

Хувийн ашиг сонирхол	Тийм	Үгүй	Хэлж мэдэхгүй байна	Тайлбар
Эрчүүдэд давуу тал олгодог тогтолцоо оршиж байна. Гэвч эргээд энэ нь эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайханд муу нөлөөтэй. Эрчүүд ослоос эрт амь насаа алдах, амиа хорлох, уул уурхай, тээвэр, хүнд үйлдвэрлэлийн салбарт хүнд хүчир ажил хийх, гэр бүлээс тусдаа ажиллах, архи тамхины өндөр хэрэглээ зэрэг асуудлууд байдаг. Эрчүүд хатуу хүтүү байх ёстой, эмнэлгийн тусламж хүсэхгүй, хайхрахгүй байх гэсэн ойлголт буруу юм.				
Ажилгүйдэл их газарт, цалинтай ажлын олдоц ховор байдаг. Эрчүүд ар гэрээ тэжээгч байх ёстой, эр хүн ийм л байдаг гэсэн ойлголттой хүмүүс орчин тойронд нь их байх нь эрэгтэйчүүдэд хортой дарамт болж болзошгүй.				
Эрэгтэйчүүд халдашгүй мундаг "дүр" эсгэн, сэтгэл хөдлөлөө "хянаж" дарах шаардлагагүйгээр амьдралын сонголтоо чөлөөтэй хийж, сэтгэл хөдлөлөө чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх ёстой. Ингэснээр сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэл зүйн хувьд эрэгтэйчүүдэд илүү ашигтай нөхцөл үүснэ.				

Хамтын ашиг сонирхол	Тийм	Үгүй	Хэлж мэдэхгүй байна	Тайлбар
Эмэгтэйчүүдийн боловсрол дээшилж, эрүүл мэнд сайжирснаас урт хугацаандаа бүх нийтийн сайн сайханд бий болгох ашиг тусыг эрэгтэйчүүд хүлээн зөвшөөрч болно. Жендэрийн тэгш байдал эрчүүдэд ч ашиг тусаа өгнө.				
Эрэгтэйчүүд өөрсдийн нийгмийн энх тайвны төлөө эдгээр хэм хэмжээ, тэгш бус байдал, үүнээс шалтгаалсан хүчирхийллийг өөрчлөх сонирхолтой байна.				

Хүний эрх, нийгмийн шударга ёс	Тийм	Үгүй	Хэлж мэдэхгүй байна	Тайлбар
Эр хүйсийн давамгайллын хортой хэм хэмжээ, практикт өөрчлөлт оруулах нь зүй ёсны хэрэг тул жендэрийн шударга ёсны тэмцэлд эрэгтэйчүүд мөн оролцох ёстой.				
Жендэрийн тэгш бус байдал системтэйгээр оршсоор байгаа үед эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс давуу эрхтэй байж, хөвгүүдэд илүү амжилттай ирээдүйг амласаар байх нөхцөлд, эрчүүдэд ч тогтолцоонд өөрчлөлт оруулахын тулд чадах бүхнээ хийх үүрэгтэй.				

Эрэгтэйчүүд өөрчлөлтөөс үр шим хүртэнэ.

Дүгнэн үзвэл эцгийн эрхт ёсноос хувьсан өөрчлөгдөгч эрчүүдийн ертөнцөд шилжсэнээр эрчүүдийн хувьд ч тэдний амин чухал ашиг сонирхол, амьдралдаа хүртэж чадах ач тус байгаа билээ. Тэдний зүгээс эр хүн ийм байх ёстой гэсэн эцгийн эрхт ёсны ертөнцөд нийцэж амьдрахдаа тэд өөрсдийн хайртай хүмүүс, гэр бүл, аз жаргалаа, өөрсдийгөө ч золиосолж байгаа гэдгээ төдийлөн ухамсарладаггүй.

4.2 ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨЛӨӨ ЭРЧҮҮД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Эрчүүд нийгмийн хүсэн хүлээсэн өөрчлөлтийн төлөө дараах хүрээнд юу хийж чадах вэ?

Дараах хүрээнээс сонгон өөрсдийн чадах зүйлээ бичиж эргэцүүлээд багийн гишүүд саналаа нэгтгэнэ үү.

Эрчүүдийн дунд: _____

Хань ижил, хамтрагчдаа: _____

Үр хүүхдүүддээ: _____

Найзууд, хамт олон дунд: _____

Орон нутагтаа: _____

Нийгмийн үйлчилгээний болон бусад байгууллагуудад:

4.3 ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨГЧ ЭРЧҮҮДИЙН ЕРТӨНЦИЙН ТУРШЛАГА

ХУВЬСАН ӨӨРЧЛӨГДӨГЧ ЭРШҮҮД БАЙДЛЫГ БҮРЭЛДҮҮЛЖ БУЙ ОЛОН УЛСЫН ТУРШЛАГААС ҮҮДСЭН СУРГАМЖУУД

Эх сурвалж: Эр хүйс ба охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай ойлголт, UN WOMEN, Сургалтын төв, 2016

Харахыг хүссэн өөрчлөлтөө өөрөө хий. Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг дэмжигч хөвгүүд, эрэгтэйчүүд хувийн харилцаа, гэр бүлийн амьдрал, нийгмийн орчинд юуг хүсдэг тухайгаа илэрхийлж, хүсч буй зүйлээ бодит үйл хэрэг болгоход тэд өөрсдөө хэрхэн хувь нэмэр оруулах талаар тунгаан бодох хэрэгтэй.

Жишээ нь: Зан үйлээ өөрчлөх

Дэмж, дэмжлэг ав. Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг дэмжигч хөвгүүд, эрэгтэйчүүдийн бүлгийн дотор харилцан дэмжих уур амьсгалыг бүрэлдүүлэх явдал юм. Тэд хамтран ажиллаж байж эцгийн эрхт ёсыг өөрчлөх зорилгодоо хүрэх болно.

Жишээ нь: Эцгийн эрхт ёсыг хадгалах хүсэлтэй бусад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн зүгээс эсэргүйцэлтэй тулгарах тохиолдолд бие биедээ тусламж өгөх, тусламж хүсэх.

“Эрх мэдэл олгож” бэхжүүл. Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг дэмжих чиглэлээр хөвгүүд, эрэгтэйчүүдэд хувийн амьдралдаа, нийгэмдээ өөрчлөлтийг бий болгоход шаардагдах ур чадвар олгож, дэмжлэг үзүүлэхэд гол анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Жишээ нь: Энэ чиглэлээр ур чадвар олгох хөтөлбөр боловсруулах, эрчүүдийг хамруулах.

“Хамтын хүчээ” бүрэлдүүл. Эцгийн эрхт ёсны эршүүд байдлыг өөрчилнө гэдэг дийлдэшгүй мэт санагдаж болзошгүй. Иймээс эрэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлж, өөрсдийн амьдралаа өөрчлөх практик ур чадварт сургахад анхаарах шаардлагатай.

Жишээ нь: Энэ чиглэлээр хүний эрх, эмэгтэйчүүдийг чадавхжуулах асуудлаар ажилладаг байгууллагуудтай хүчээ нэгтгэх.

Холбоотон бол. Эцгийн эрхт ёс нь эрэгтэйчүүдийн "төрөлхийн" эрх мэдэл, манлайллын тухай итгэл үнэмшилд суурилдаг бол хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлын төлөө ажилд хөвгүүд, эрчүүдийн зүгээс охид, эмэгтэйчүүдийн манлайллыг бэхжүүлэх шаардлагатай арга хэмжээг авах, охид эмэгтэйчүүдтэй холбоотон болох нь чухал юм.

Хариуцлагатай бай. Эр хүйсийн давуу эрхийг илүү хариуцлагатай эдлэхэд хөвгүүд, эрчүүдийг сургаж, дэмжих нь гол сургамж юм. Эрчүүдийг илүү хариуцлагатай байхад сургаж жендэрийн тэгш байдалд хүргэхэд ач холбогдолтой.

Жишээ нь: Зан үйлээ өөрчилж, эр хүйсийн давуу талыг өөгшүүлэн, бататгах явдлыг зогсоох.

Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг бүрэлдүүлж буй олон улсын туршлагаас үүдсэн сургамжуудын талаар хажуугийн оролцогчидтойгоо харилцан ярилцаж, өөр хоорондоо тайлбарлан өгнө үү.

Монголд дээрх туршлагуудыг хэрэгжүүлж болох талаар өөр хоорондоо ярилцана уу.

Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдал өөд шилжих аливаа үйл ажиллагаанд баримтлах дараах зарчмуудыг өөрийн ойлгож байгаагаар товч тайлбарлан бичнэ үү.

ЖСХ-ийн эсрэг хөдөлгөөн, тэмцэлд нэгдэж байгааг илэрхийлэх:

Хор хөнөөл бүү учруул:

Жендэрийн өөрчлөлтийг дэмжихэд эрэгтэйчүүдийн сонирхлыг татах:

Эрэгтэйчүүд болон эр хүйстэн давамгай байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлэх:

Эрэгтэйчүүдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөх:

Хүйсийн олон янз байдал, бэлгийн чиг хандлагыг хүлээн зөвшөөр:

Эерэг мессеж бүхий олон стратеги ашигла:

Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдал өөд шилжих аливаа үйл ажиллагаанд баримтлах зарчим
ЖСХ-ийн эсрэг хөдөлгөөн, тэмцэлд нэгдэж байгааг илэрхийлэх. Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлын төлөө үйл ажиллагаа нь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд эмэгтэйчүүдийн тэргүүлсэн санаачлагуудтай хамтран ажиллаж, хүрсэн үр дүнгээ баталгаажуулах нь чухал.
Хор хөнөөл бүү учруул. Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг дэмжих чиглэлээр ажиллах бүхий л санаачлагуудын мессеж, дүрслэл нь охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход ашиг тусаа өгдөг байх, мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн талаар хэвшмэл уламжлалт үзэлд санаандгүйгээр дэм болохгүй байхад анхаарах шаардлагатай.
Жендэрийн өөрчлөлтийг дэмжихэд эрэгтэйчүүдийн сонирхлыг татах. Санал, санаачлагуудад соёлын ялгаатай орчинд эр хүн байхын утга учрыг тодорхойлохдоо жендэрийн тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалт, эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийлэлд энэ нь хэрхэн нөлөөлж болохыг эргэцүүлэн ойлгох шаардлагатай. Эрэгтэйчүүд шийдлийн нэг хэсэг болохыг мартах ёсгүй.
Эрэгтэйчүүд, эр хүйстэн давамгай байгууллагуудын хариуцлагыг дээшлүүлэх. Эрэгтэйчүүдийг асуудал шийдвэрлэхэд татан оролцуулахдаа сексист буюу хүчирхийлэгч зан төлөвийг үл дэмжих, хувийн болон бодлогын үйл ажиллагаандаа эрэгтэйчүүд хариуцлага хүлээх ёстой гэдгийг тодотгохын зэрэгцээ, бүх эрэгтэйчүүд хүчирхийлэл үйлддэггүй болохыг илэрхийлсэн үг хэллэг ашиглах нь онцгой чухал.
Эрэгтэйчүүдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөх. Эрэгтэйчүүд ч мөн адил тэгш бус нөхцөлтэй тулгардаг. Эрэгтэй хүн шударга бус байдалтай хэрхэн тулгарч буйг олж тодорхойлж, үүнийг шийдвэрлэх нь тэднийг охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, жендэрийн эрх тэгш байдлыг нийтээр тогтоох хүчин зүтгэлд татан оролцуулахад чухал үүрэгтэй.
Хүйсийн олон янз байдал, бэлгийн чиг хандлагыг хүлээн зөвшөөр Хүйсийн олон янз байдал, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хүндэтгэдэг хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдлыг сурталчлах нь чухал юм.

Хувьсан өөрчлөгдөгч эршүүд байдал өөд шилжих аливаа үйл ажиллагаанд баримтлах зарчим

Эерэг мессеж олон стратеги ашигла.
Эршүүд байдал, хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг илүү ойлгон хүлээн авахад аливаа шүүмжлэлээс ангид, мэдэхгүйгээсээ ичиж зоволгүйгээр асуулт асууж, "эмэгтэйчүүдийн асуудлаар" өөрсдийн санал бодлыг илэрхийлэн оролцох "аюулгүй" орчинг бүрдүүлэх нь чухал. Мөн доор дурдсан бусад стратегийг баримтлах хэрэгтэй:

- Олон нийтэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих, 'жинхэнэ эрчүүд' хүчирхийлэл үйлддэггүй, эмэгтэйчүүд тэгш эрхтэй гэдгийг таниулж, ялангуяа эрэгтэйчүүдийн дунд хүчирхийлэлгүй хандлагыг бэхжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах.
- Олон нийтийн дунд төрөл бүрийн боловсрол, сурталчилгаа, арга хэмжээ бүхий стратеги баримтлан нийгмийн хэм хэмжээнд нөлөөлөх, хөвгүүд, эрэгтэйчүүдийн дунд эршүүд байдал, хүчирхийллийн тухай уламжлалт хэвшмэл ойлголтоос татгалзах орчинг бүрдүүлэх.
- Хувь хүний эерэг өөрчлөлтийг дэмжих, энэ нь нийгэмд эерэг өөрчлөлтийг бүрдүүлж байгаа бол орон нутагт сурталчлах.

Эх сурвалж: Эр хүйс ба охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай ойлголт, UN WOMEN, Сургалтын төв, 2016

ТА ЖСХ-ЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН КОМПАНИТ АЖЛУУДАД ОРОЛЦОХ БОЛОМЖТОЙ:

Анх 1991 онд Эмэгтэйчүүдийн Глобал Манлайлал Хүрээлэнгээс "**Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян**"-ыг жил бүр зохион байгуулах санаачлагыг гаргасан ба Монгол Улсад 1997 оноос эхлэн Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв санаачлан НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр өнөөг хүртэл жил бүр тасралтгүй зохион байгуулж ирсэн. Тус аян нь Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгах олон улсын өдөр болох 11 сарын 25-наас эхлэн Олон улсын хүний эрхийн өдөр болох 12 сарын 10-ны өдөр хүртэлх 16 хоногийн турш үргэлжилдэг.

Facebook: @16DayCampaignMongolia

Анх 1989 оны 12 сарын 6-нд Канад улсын Монреаль хотод болсон үйл явдалаас үүссэн ба Монгол Улсад 1997 оноос эхлэн "**Цагаан туузтаны аян**"-ыг Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв ТББ санаачлан жил бүр зохион байгуулж ирсэн. Энэ хөдөлгөөнд оролцсон эрчүүд бусад эрчүүдэд Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход хариуцлагатай байх ёстойг уриалдаг онцлогтой. Дэлхийн цагаан туузтаны өдөр жил бүрийн 11 сарын 25-нд болдог.

Facebook: Цагаан туузтаны аян Монголд /White ribbon movement Mongolia

"Нэг тэрбумаараа тэмцье!" охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох дэлхий нийтийн хөдөлгөөнийг Монгол Улсад "Хөөрхөн Зүрх" ТББ-ын санаачилгаар хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоохын төлөө олон улсын хөдөлгөөнийг 2013 оноос хойш өрнүүлж байна.

Facebook: @OBRMongolia

Familycenter.mn вебсайт Танд:

- Гэр бүлийн эрүүл, эерэг харилцааны соёлыг түгээх,
- Гэр бүлийн зөрчил маргааныг эерэгээр шийдвэрлэх,
- Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн ойлголт мэдлэгийг өгөх,
- Зан үйлээ өөрчлөхөд нөлөөлөх,
- Жендэрийн хэвшмэл үзэл, ойлголтыг халахад чиглэсэн зөвлөгөө, мэдээлэл, тусламж үзүүлнэ.

/Family Center Familycenter.mn